



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 8/9

Сант сум

Г  
Мод бэлтгэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, 18.2.7 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 сарын 06-ний өдрийн 56 тоот тогтоолыг тус тус ундэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн ойн сангаас 2023 онд арчилгааны огтлолтоор хэрэглээний Шинэс 50м/куб, улиангар 50м/куб, түлээ шинэс 33м/куб модыг "Шинэ орос хийц" ХХК, шинэс 50м/куб, улиангар 50м/куб, түлээ шинэс 33м/куб модыг "Хэт жолоо" ХХК тус тус гэрээ байгуулах, бэлтгэх модны 50%-ыг сумын иргэдэд олгох, ойн санг гэрээгээр эзэмшигч "Алтансүмбэр" нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар хэрэглээний шинэс 30м/куб, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хус 25м/куб, түлээ шинэс 100м/куб, Улиангар 20м/куб, "Баян Баавгайт" нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар хэрэглээний шинэс 20м/куб, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хус 25м/куб, түлээ шинэс 20м/куб, "Хан хушаат" нөхөрлөл цэвэрлэгээний ажлаар хэрэглээний шинэс 30м/куб, түлээ 100м/куб мод, цэвэрлэгээний ажлаар хэрэглээний шинэс Ивэн 1-р багт 110м/куб, Хушаат 2-р багт 90м/куб мод, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх бургас Ивэн 1-р багт 25м/куб, Хушаат 2-р багт 25м/куб мод тус тус бэлтгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сант сумын иргэдийн хэрэгцээний галын түлээ Ивэн 1-р багт 2000м/куб, улиангар 40м/куб, Хушаат 2-р багт шинэс 1760м/куб, улиангар 40м/куб модыг ойгоос мод бэлтгэх чадавхи бүхий иргэдэд өрхийн хэрэгцээний 8м/куб хэмжээгээр, бусдын түлээний хэрэгцээг орлого олох зориулалтаар мод бэлтгэж арилжаалдаг ажлыг модны захиалга, мод бэлтгэж худалдан борлуулах хүсэлт гаргасан иргэдээр гэрээгээр гүйцэтгүүлэхийг дэмжин ажилласугай.

3. Ойгоос бэлтгэгдэх хэрэглээний модны талбай тусгаарлах ажлыг сум дундын ойн ангиар хугацаа алдалгүй гүйцэтгүүлэх, ойн нөхөрлөлүүдийн бэлтгэх хэрэглээний модыг зохих хугацаанд нь бэлтгүүлэх, галын түлээг хэрэгцээт иргэдэд олгох, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг БОХУБ (А.Батдорж), Байгаль хамгаалагч (Ч.Төгсбаатар, Г. Ганжолоо) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.

  
С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

43151019

Боловсруулсан: Ч.Тогсдааев  
Хянасан: Ч.Тогсдааев  
Хувь: 2.  
Огноо: 2023. 02. 15.